



2017 оны II улирлын
“МОНГОЛБАНКНЫ ЭССЕНИЙ ТЭМЦЭЭН”-ий удирдамж

НЭГ. СЭДЭВ: “Би нийгэмд ямар үнэ цэнийг бүтээдэг вэ?”

Тайлбар:

Иргэд, аж ахуйн нэгжүүд, төрийн байгууллагууд г.м. эдийн засагт оролцогчид өөр хоорондоо ялгаатай маш олон төрлийн үйл ажиллагааг эрхэлж байдаг. Тэдгээр нь дуу дуулах, хөгжим тоглох, спортын тэмцээн уралдаанд оролцох, бизнес эрхлэх, судалгаа хийх, бодлого тодорхойлох, хоол хийх, үс засах, гэр орны ажил, амралт, хүүхэд асрах гээд олон янз байж болно. Нэг жил, нэг улирал г.м. тодорхой цаг хугацаанд эдийн засагт оролцогчид нийлбэр дүнгээрээ хэр их зүйл бүтээсэн бэ гэдгийг мөнгөн дүнгээр хэмжих нэг арга нь Дотоодын нийт бүтээгдэхүүн (ДНБ) юм. ДНБ нь ихэнхдээ аль нэг салбар эсвэл улс орны хэмжээнд хэр их үйлдвэрлэл, үйлчилгээ явагдсан бэ гэдгийг хэмждэг бөгөөд зах зээл дээр арилжаалагддаггүй зүйлсийг, мөнгөөр илэрхийлэгдэхгүй зүйлсийг хэмждэггүй г.м. онцлог бий. Харин хувь хүний бүтээсэн зүйлийн үнэ цэнийг зах зээл дээрх цалин хөлс эсвэл борлуулалтын орлогоор хэмжиж болох ч, мөнгөөр илэрхийлэгдэхгүй хэсэг ч бий. Тэгвэл **Та өөрийн хамгийн их зүтгэл гарган хийж буй зүйлээ хэрхэн гүйцэтгэдэг талаар тайлбарлан, тэрхүү үйл ажиллагаагаараа дамжуулж нийгэмд ямар үнэ цэнийг бүтээж буй, хийдэг зүйл тань нийгэмд оруулья гэж хүсдэг зүйлтэй чинь хэр их нийцдэг зэргийг хамруулан бичнэ үү.**

ХОЁР. ШАЛГАРУУЛАЛТ

✓ **Шагнал:**

I байр: 300,000 төгрөг + Өргөмжөл

II байр: 200,000 төгрөг + Өргөмжөл

III байр: 100,000 төгрөг + Өргөмжөл

- ✓ Шалгарсан бүтээлүүдийг Монголбанкны албан ёсны вебсайт, социал сувгуудаар олон нийтэд түгээнэ.
- ✓ **Материал хүлээн авах хугацаа (хугацааг 2 долоо хоногоор сунгасан):** 2017.05.22 (Даваа)18.00 цаг хүртэл essay@mongolbank.mn хаягаар хүлээн авна.
- ✓ **Тэмцээний үр дүнг зарлах хугацаа:** 2017.06.15

ГУРАВ. ЭССЕНД ТАВИГДАХ ШААРДЛАГА

- ✓ Эссег дараах шалгуураар үнэлнэ:

	Оноо
Ерөнхий шаардлага	
<i>Цаг бартимтлал /18:00 цагаас хоцорсон бол -10 оноо/</i>	10
<i>Үгийн тоо /800-1000 үг/</i>	5
<i>Бичгийн стандарт /Фонт, үсгийн хэмжээ, маржин.../</i>	5
Асуултад хариулсан байдал	
<i>Өөрийн хийдэг зүйлээ тодорхойлсон байдал</i>	10
<i>Нийгэмд бүтээж буй өөрийн үнэ цэнийг тодорхойлсон байдал</i>	10
Эссений чанар	
<i>Үг үсгийн алдаа</i>	5
<i>Найруулга зүй</i>	5
<i>Логик дэс дараалал</i>	10
<i>Судалгаа/Тоо баримт ашигласан байдал</i>	10
<i>Энгийн ойлгомжтой байдал</i>	10
<i>Уншихад сонирхолтой байдал</i>	10
<i>Оригиналь санаа /давтагдаагүй/</i>	10
Нийт	100

- ✓ 800-1000 үгэнд багтаан Монгол хэлээр бичих;
- ✓ Үг үсгийн болон утга найруулгын алдаагүй байх;
- ✓ Бусдын оюуны бүтээлийг зөвшөөрөлгүй хуулбарлаагүй байх (Иш татсан тохиолдолд тогтсон стандартыг баримтлах);
- ✓ Бичгийн стандарт:
 - Үсгийн фонт: Times New Roman;
 - Үсгийн хэмжээ: 12;
 - Мөр хоорондын зай: 1,5;
 - Margins: дээд захаас 20 мм, доод захаас 20 мм, зүүн захаас 30 мм, баруун захаас 15 мм.
- ✓ Нүүр хуудсанд өөрийн нэр, ажил, мэргэжил, холбоо барих 2 утас, и-мэйл хаягийг бичих;
- ✓ “Монголбанкны эссений тэмцээн” нь дээрх шаардлагыг хангасан материал илгээж буй оролцогч бүрт нээлттэй бөгөөд мэргэжил, нас, хүйс, иргэншил харгалзахгүй болно.

Бага тойруу 3, 15160, Улаанбаатар, Монголбанкны “Б” байр
Монголбанкны Олон нийтийн боловсрол, мэдээллийн төв
Дэлгэрэнгүй мэдээллийг www.mongolbank.mn веб хуудаснаас болон (976) 11-310119
утсаар лавлана уу.